



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурьдсан Монголын хөрөнгийн биржийн гишүүн нэр бүхий үнэт цаасны компанийн ажилтанд үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх олгох ажил зохион байгуулахыг Захиргааны алба /Ж.Нарантуяа/-д, арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Арилжааны алба /Б.Чингүнжав/-д тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР